



ДУНДГОВЬ АЙМГИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 11 сарын 22 өдөр

Дугаар А/23

Мандалговь


Аймгийн аварга шалгаруулах
насанд хүрэгчдийн волейболын тэмцээнд
зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2021 оны 11 дүгээр сарын 20,21-ний өдөр зохион байгуулагдсан Аймгийн аварга шалгаруулах насанд хүрэгчдийн волейболын тэмцээний төсвийг нэгдүгээр хавсралтаар, шүүгч нарын нэрсийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Тэмцээний зардалд шаардагдах 496,800 (Дөрвөн зуун ерэн зургаан мянга найман зуу) төгрөгийг тэмцээн уралдааны зардлаас гаргахыг ерөнхий нягтлан бодогч (Б.Мөнхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



А.ОТГОНБААТАР